

МОНГОЛ УЛСЫН ГАДААД ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨНИЙ СУДАЛГААН ДАХЬ ТУЛГАМДСАН АСУУДАЛ: МЭДЭЭЛЛИЙН ЭХ ҮҮСВЭР, ЧАНАР

Батцэнгэлийн Мөнхжаргал, (Ph.D), Монгол Улсын Их Сургууль, Шинжлэх Ухааны Сургууль, Нийгмийн Ухааны Салбар, Эдийн засгийн тэнхимийн ахлах багш

Хураангуй

Монгол Улсад хүн амын орчин үеийн гадаад шилжих хөдөлгөөн 1990-ээд оноос эхлэлтэй ч холбогдох судалгааны ажлууд харьцангуй хангалтгүй явагдаж ирсний нэг үндсэн шалтгаан нь тоо мэдээллийн олдоц, чанартай холбоотой. Энэхүү ажлаар Монгол Улсын гадаад шилжих хөдөлгөөний гол анхдагч мэдээллийн эх үүсвэрүүдийг шүүх замаар тоо мэдээллийн өнөөгийн боломж, мэдээллийн ашиглалтад тулгарч буй хүндрэлүүдийг тодорхойлж, мэдээллийг сайжруулах чиглэлээр санал дэвшүүлэхийг зорьсон. Боломжит мэдээллүүдээс харахад Монгол Улсын гадаад шилжих хөдөлгөөний талаарх анхдагч мэдээллийн эх үүсвэрүүд хангалттай олон төрөл байгаа ч тэдгээрт шилжих хөдөлгөөний динамикаар судлах боломж муу, зарим төрлийн шилжих хөдөлгөөний мэдээлэл огт байхгүй, мэдээллийн хамралт дутуу, зарим мэдээлэлд олон улсад мөрдөгддөгөөс зөрүүтэй ойлголт, тодорхойлолтууд хэрэглэдгээс харьцуулсан судалгаа хийхэд хүндрэлтэй, захиргааны бүртгэлийн мэдээлэл бүрдүүлэлт хангалтгүй, мэдээллүүдийн хоорондын нийцэл хангалтгүй зэрэг олон анхаарах асуудлууд байна.

Түлхүүр үгс: Гадаад шилжих хөдөлгөөн, гадаад шилжих хөдөлгөөний мэдээллийн эх үүсвэр, гадаад шилжих хөдөлгөөний мэдээллийн хамралт, гадаад шилжих хөдөлгөөний мэдээллийн чанар, шилжих хөдөлгөөний урсгал буюу *flow* мэдээлэл, шилжих хөдөлгөөний *stock* буюу *шилжин суурьшигчдын* мэдээлэл

Abstract

One of the main reasons for inadequate studies on international migration of Mongolia, while the contemporary international migration history of Mongolia has been recorded since 1990s, is related to availability and quality of international migration data. This study intended to explore the current availability of international migration data and complications during its applications based on review of the main primary data sources of international migration in Mongolia and to develop some recommendations on improvements of data. The review of available data shows that although there are multifarious primary data sources of international migration in Mongolia, many problems, such as poor availability of study on dynamic trend, lack of some types of migration data, incomplete data coverage, internationally incomparable data due to usage of different definitions on main concepts, poor quality and coverage of administrative data, and poor data consistency between data sources, are observed.

Key words: International migration, data sources of international migration, data coverage of international migration, data quality of international migration, flow data of migration, stock data of migration

1. ОРШИЛ

Улс орнууд шилжих хөдөлгөөн ба хөгжил хоорондын чухал холбоо хамаарлыг таньж мэдэх болсноор, шилжих хөдөлгөөн болон шилжигчдийн асуудлыг олон улсын хөгжлийн зорилтуудад тусган анхаарах болсон. Тухайлбал, НҮБ-ын Ерөнхий Ассамблейгаар 2015 онд батлагдсан дэлхий нийтийн урт хугацааны хөгжлийн бодлого болох “Тогтвортой хөгжлийн зорилго-2030”-д шилжих

хөдөлгөөнийг шууд нэрлэн заасан болон шууд бусаар шилжих хөдөлгөөнтэй холбогдуулсан агуулга бүхий 7 үндсэн зорилго, 10 зорилтууд байна (IOM GMDAC, 2018). Ялангуяа, Зорилт 10.7 нь шилжих хөдөлгөөний асуудлыг шууд тусгасан зорилт бөгөөд “Төлөвлөлт, зохицуулалт сайтай шилжилт хөдөлгөөний бодлого хэрэгжүүлэх замаар хүмүүсийн зохион байгуулалттай, аюулгүй, албан

ёсны, хариуцлагатай шилжилт хөдөлгөөнийг дэмжих” талаар заажээ. Мөн Зорилт 10С-д “2030 он гэхэд шилжин суурьшигчдын мөнгөн гуйвуулгын гүйлгээний зардлыг 3 хувиас бага түвшинд хүртэл бууруулж, 5 хувиас дээш зардалтай мөнгө гуйвуулах үйлчилгээг зогсоох” гэж заасан байна (UN DESA, PD, 2017). Ийнхүү хөгжлийн томоохон зорилтод шилжих хөдөлгөөний асуудлыг тусгаснаар, улс орнуудын өмнө албан ёсны статистикуудаар тоо мэдээлэл гаргаж, үнэлгээ хийх үүрэг хариуцлага ногдох болсон.

Гадаад шилжих хөдөлгөөний хандлага, түүний шалтгаан, үрнөлөөг судалж бодлоготөлөвлөлт, хэрэгжүүлэлт, үнэлгээнд ашиглахад макро, мезо, микро түвшний, динамик, чанартай мэдээлэл чухал. Гэвч дэлхий даяар хүн амын гадаад шилжих хөдөлгөөний бүртгэл мэдээлэл олон улс оронд, ялангуяа хөгжиж буй орнуудад хангалтгүй байна (UN DESA, PD, 2012). Монгол Улсын хувьд улс төр, нийгэм, эдийн засгийн тогтолцооны онцлогоос хамааран хүн амын гадаад шилжих хөдөлгөөн 1990-ээд оныг хүртэл харьцангуй хаалттай, бага түвшинд байсан. Гэвч хөдөлгөөн идэвхжсэн 1990-ээд оноос өнөөг хүртэл Монгол Улсын хүн амын гадаад шилжих хөдөлгөөнтэй холбоотой тоо мэдээлэл, ялангуяа макро түвшний мэдээлэл хамралт, хүртээмж, чанарын хувьд нэлээд дутагдалтай явж ирсэн. Энэ нь микро түвшинд хийж болох гадаад шилжих хөдөлгөөний судалгаануудын түүвэрлэлтийг магадлалт түүвэрлэлтээр хийх боломжийг хязгаарлах, түүнчлэн гадаад шилжих хөдөлгөөний үр нөлөөг мезо, макро түвшинд судлах зэрэг судалгааны чиглэлүүдийг хязгаарлагдмал байх нэг үндсэн хүчин зүйл болсоор байна.

Иймд энэхүү ажлаар хоёрдогч тоо, мэдээлэл, судалгааны ажлуудад үндэслэн Монгол Улсын гадаад шилжих хөдөлгөөний анхдагч мэдээллүүдийн боломж, мэдээллийн ашиглалтад тулгарч буй хүндрэлүүдийг тодорхойлохыг зорьлоо. Тус мэдээлэлд үндэслэн мэдээлэл цуглуулах, бүрдүүлэх, боловсруулах, тархаах чиглэлээр ажилладаг мэргэжлийн байгууллага, судлаачид Монгол Улс дахь гадаад шилжих хөдөлгөөний мэдээллийн тулгамдсан асуудлуудыг шийдэхэд чиглэсэн арга хэмжээ авч, улмаар Монгол Улсын хүн амын гадаад шилжих хөдөлгөөний судалгаа, эрдэм шинжилгээний ажлуудыг цаашид өргөжүүлэхэд хувь нэмэр оруулах боломжтой гэж үзэж байна. Мөн шилжих хөдөлгөөний чиглэлээр ажилладаг

мэргэжилтнүүд, судлаачдын анхаарлыг гадаад шилжих хөдөлгөөний судалгааны бодит тулгамдсан асуудал руу хандуулж, хэлэлцүүлэг өрнүүлэх нь ажлын өөр нэгэн “далд” зорилго болно.

Энэхүү ажлыг баримт бичгийн судалгааны аргаар гүйцэтгэсэн ба хэвлэгдсэн тоо, баримт бичиг, анхдагч эх үүсвэрүүдийн мэдээлэл цуглуулах маягт, хууль, дүрэм журам, гарын авлага, судалгааны тайлан, эрдэм шинжилгээний өгүүлэл, захиргааны буюу албан хэрэгцээнд цуглуулсан зарим мэдээ, материалыг ашигласан.

2. ГАДААД ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨНИЙ МЭДЭЭЛЛИЙН ТӨРӨЛ БА МЭДЭЭЛЛИЙН ЭХ ҮҮСВЭРИЙН ТУХАЙ

Шилжих хөдөлгөөн нь олон хэлбэрээр илэрдгээс гадна хувь хүний хувьд цаг хугацаа болон байршлаар дахин давтагдаж болдог, олон үе шат/цикл¹-ээр үргэлжлэх боломжтой тул хэмжих болон мэдээлэл бүрдүүлэх талаасаа нэлээд хүндрэлтэй судлагдахуунуудын нэг юм. Тухайлбал, зарим хүн аль нэг улс руу хэд хэдэн удаа шилжин очиж, буцаж ирж байхад зарим хүн буцахгүйгээр бүрмөсөн шилжин суурьшдаг, мөн зарим шилжигчид оршин суух эрхийн хугацаагаа хэтрүүлэн бүртгэлгүйгээр гадаадад оршин суудаг. Түүнчлэн, шилжих хөдөлгөөнд оролцогчдыг тодорхойлох, ангилах улс орнуудын аргачлал ялгаатай байгаагаас улс орнуудын хооронд харьцуулсан судалгаа хийхэд хүндрэлтэй байдаг.

Улс орнууд хүн амын гадаад шилжих хөдөлгөөний мэдээллийг бүртгэж, түвшин, хандлагыг хэмжихдээ а) *гадаад шилжих хөдөлгөөний урсгал* (international migration flows); б) *гадаадад шилжин суурьшигчид* (international migration stock) гэсэн хоёр үндсэн мэдээллийг ашигладаг. НҮБ-ын тодорхойлолтоор, шилжих хөдөлгөөний *flow буюу урсгал* гэдэг нь хилээр орох, гарах гэсэн хоёр хөдөлгөөнийг багтаах ба авч үзэж буй хугацааны турш тодорхой улсад орж ирсэн шилжигчдийн тоог *орох урсгал* (inflows or immigrants), ижил хугацааны турш тухайн улсаас гарсан шилжигчдийн тоог *гарах урсгал* (outflows or emigrants) гэнэ. Харин *stock буюу*

¹ Шилжих хөдөлгөөний цикл гэдэг нь нэг улсаас шилжин явах, зарим тохиолдолд өөр улсаар дамжин өнгөрөх, өөр улсад шилжин очих, буцаж эх орондоо шилжих гэсэн шилжилт хөдөлгөөний үе шатуудыг хэлдэг.

шилжин суурьшигчид гэдэг нь тодорхой хугацаа (жилийн эцэс, улирлын эцэс гэх мэт)-ны мөчид судалж буй улсад оршин суугаа “байнга оршин суудаг улсаа өөрчилсөн” гадаад иргэдийн нийт тоог хэлнэ. Улс орнуудад энэ үзүүлэлтийг хэмжихдээ, заагдсан хугацааны шалгуураас дээш хугацаагаар төрснөөсөө өөр улсад амьдарч байгаа хүн (гадаадад төрсөн хүн)-ий тоо, эсвэл амьдарч байгаа улсынхаасаа өөр иргэний харьяалалтай хүн (гадаадын харьяат хүн)-ий тоогоор хэмжих нь түгээмэл байдаг. Аль нэг улсын хувьд, тухайн улсад оршин сууж буй гадаадын харьяат иргэд болон тухайн улсаас гадаадад оршин сууж байгаа өөрийн харьяат иргэд гэсэн 2 төрлийн мэдээллийг гаргана.

Гадаад шилжих хөдөлгөөний flow болон stock хэмжүүр нь шилжих хөдөлгөөнийг хоёр өөр талаас нь хэмжиж байгаа тул хоёулаа чухал үзүүлэлт юм. Тухайлбал, stock мэдээлэл нь шилжих хөдөлгөөний хуримтлагдсан дүнг харуулж байхад, flow мэдээлэл нь хөдөлгөөнийг ажиглагдсан тухай бүрт нь харуулж, шилжих хөдөлгөөний төрөл, идэвхжилтийн талаар илүү сүүлийн үеийн дүр зургийн мэдээлэл өгдөг. Сул талаас нь харвал, flow мэдээллээс гадаад шилжих хөдөлгөөн хүн амыг хамрах хүрээний хувьд нэмэгдэж үү, эсвэл шилжих хөдөлгөөнд өмнө оролцсон хүмүүсийн давтан шилжих хөдөлгөөнд оролцох байдал нэмэгдсэн үү гэдгийг ялгах, мөн иргэдийн хэчнээн нь хэр удаан гадаадад оршин суусан, буцах шилжих хөдөлгөөн ямар байгаа зэргийг судлахад хүндрэлтэй байдаг. Ийм тохиолдолд stock мэдээлэл чухал үүрэгтэй.

Олон улсад stock буюу гадаадад шилжин суурьшигчдын талаарх мэдээллийн анхдагч эх сурвалж нь хүн амын тооллого; хүн ам, өрхийн бүртгэл; үндэсний түүвэрлэлттэй өрхөд суурилсан судалгаа зэрэг болж байна. Харин flow буюу шилжих хөдөлгөөний урсгалын мэдээлэл нь ихэвчлэн захиргааны бүртгэл статистикууд, мөн хүн амын тооллогоос гардаг.

Хүн амын тооллого нь гадаад шилжих хөдөлгөөнийг олон улс хооронд харьцуулан судлахад хамгийн тохиромжтой² мэдээллийн эх үүсвэр юм. Энэ эх үүсвэрээр тооллогоос өмнөх тодорхой хугацааны гадаад шилжих хөдөлгөөнд оролцогчдын тоо, тэдгээрийн шинж байдал, мөн тооллогын үеийн хүн амын төрсөн улс, иргэний харьяалал зэрэг чухал мэдээллүүд гардаг. Гэхдээ тооллогод гадаад шилжилт хөдөлгөөний асуултын тоо маш хязгаарлагдмал, мөн албан бус, бичиг баримтгүй шилжигчдийн дунд тооллогод хамрагдахгүй байх хандлага гардаг, тооллого 10 жил тутамд 1 удаа л явагддаг тул цаг үеийн өөрчлөлтүүдийг дор бүрд нь судлах боломж олгодоггүй, зарим орны тооллого “бэлэн хүн ам”-аа³ тоолдог байхад зарим нь “суурин хүн ам”-аа⁴ тоолдог зэрэг сул талтай.

Хүн ам, өрхийн бүртгэл нь тухайн орны оршин суугч хүн тус бүрийн хаяг, байршлаа өөрчлөх хөдөлгөөний талаарх мэдээллийг регистрийн дугаарт үндэслэн, эсвэл өрхийн амьдардаг хаяг, засаг захиргааны нэгжид үндэслэн цуглуулдаг. Энэ эх үүсвэрээр хүн амын дотоод, гадаад шилжих хөдөлгөөний мэдээллийг авч болох ч бүртгэл нь ихэвчлэн хуулийн хүрээнд тухайн оронд хамааралтай хүмүүс буюу суурин хүн амыг хамардаг. Мөн тухайн орны оршин суугчдын эх орноосоо гарах, орох шилжилт хөдөлгөөнүүдийг тухайн хөдөлгөөн гарах тухай бүрт бүртгэж мэдэх боломжтой хэдий ч хуулийн зохицуулалт, хэрэгжилт зэргээс хамааран дутуу бүртгэл их байдаг. Энэ эх үүсвэрээр гадаад шилжих хөдөлгөөний чанартай мэдээлэл авах боломж одоогоор зөвхөн иргэний бүртгэлийн систем өндөр хөгжсөн орнуудад байгаа⁵ гэж үздэг (UN DESA, Statistics Division, 1998; Edmonston.B & M.Michalowski, 2004).

Түүвэр судалгаанууд нь хэрэв эх олонлогоо төлөөлж чадахуйц түүвэртэйгээр хийгдсэн бол гадаад шилжих хөдөлгөөнийг шинж чанар, шалтгаан, үр нөлөө зэргээр нь гүнзгийрүүлэн судлахад хамгийн сайн эх үүсвэр болдог.

² Тооллогоор хувь хүн нэг бүрийг хамруулдаг, амьдарч буй газар нутгийн талаарх мэдээллийг авдаг, бүх орны тооллого нэг ижил онуудад, тогтмол давтамжтайгаар явагддаг.

³ Бэлэн хүн амын тооллого нь тооллогын цаг мөчид тухайн улсын нутаг дэвсгэрт байнга амьдарч байгаа тухайн улсын харьяат, гадаадын харьяат болон харьяалалгүй хүмүүсийг тоолно.

⁴ Суурин хүн амын тооллого нь тооллогын мөчид тухайн улсын газар нутагт болон бусад улс оронд байнга амьдарч байгаа тухайн улсын харьяат иргэдийг тоолно.

⁵ Австри, Белги, Дани, Финланд, Герман, Исланд, Итали, Люксембург, Нидерланд, Норвеги, Испани, Швед, Швейцарь, Азийн Япон, Тайвань, Израйл гэх мэт орнуудын иргэний бүртгэлээр гадаад, дотоод иргэдийн хэн хэнийх нь хөдөлгөөнийг бүртгэдэг бол хуучин ЗХУ-ийн системд байсан зүүн болон төв Европын зарим орнуудад иргэний бүртгэл боломжийн сайн хөгжсөн ч гадаад иргэдийн хөдөлгөөний бүртгэлийг хийдэггүй.

Гэхдээ нийт эх олонлогийг хамарч чаддаггүй, тогтмол давтамжтайгаар явагдаж чаддаггүй тул динамик хандлага харах боломжгүй, бусад судалгаатай харьцуулалт хийхэд хамарсан хүрээ ба агуулгын хувьд өөр, харьцуулахад төвөгтэй байдаг.

Захиргааны бүртгэлүүд нь гадаад шилжих хөдөлгөөнийг хянах, зохицуулах, удирдах чиглэлээр ажилладаг байгууллагуудын бүртгэлээс бүрддэг. Тухайлбал, үүнд виз олголтын бүртгэл, гадаадын иргэн, харьяатын газрын гадаадын иргэдэд ажиллах, оршин суух, цагаачлах, гарах, статусаа өөрчлөх зэрэг зөвшөөрөл олгосон бүртгэл, хилийн хяналтын орох, гарах хөдөлгөөний бүртгэл зэрэг ордог. Захиргааны эх үүсвэрийн мэдээлэл нь тооллогыг бодвол цаг үеэсээ хоцроогүй шинэ мэдээлэл байдаг ч өөр байгууллагуудын өөр хэрэгцээнд цуглуулсан мэдээллүүд тул хооронд нь нэгтгэж, харьцуулан судлахад хүндрэлтэй байдаг. Мөн хилийн бүртгэлийн үед шилжих хөдөлгөөний хэлбэрүүдийг нарийн ялгаж бүртгэхэд хэцүү, гадаадад байсан хугацаа болон шилжилтийн зорилгын мэдээллийг хүмүүс бодитоор хэлэхгүй байх хандлага түгээмэл байдаг, хараа хяналтгүйгээр хил нэвтрэх хандлага ч байдаг тул чанар болон хамрагдалтын хувьд хангалтгүй байх талтай. Үүнээс гадна, уг мэдээлэл нь засаг захиргааны үйл явцаас гардаг тул статистик мэдээлэл болгон боловсруулах байдал хангалтгүй байдаг. Мөн гадаадын шилжин


ирэгч хүмүүст илүү анхаарал хандуулан нарийн бүртгэх, гадагш явах урсгалын хяналт сул, бүртгэлийг нь хангалтгүй хийх хандлага ихэнх улсад байдаг. Захиргааны бүртгэлүүд нь мөн шилжих хөдөлгөөний олон төрлүүдийг цогцоор нь биш, зарим нэг рүү сэдэвчилсэн байдлаар анхааран мэдээлэл бүрдүүлсэн байдаг нь асуудлыг цогцоор судлах боломж олгодоггүй.

Ерөнхийд нь дүгнэвэл, улс орнуудад гадаад шилжих хөдөлгөөний судалгаа хийхэд мэдээллийн талаас тулгардаг гол хүндрэлүүд нь:

- Өөр эх үүсвэрүүдээр олон төрлийн шилжигчдийн мэдээллүүд тус тусдаа цуглуулагддаг ба мэдээлэл хоорондын хугацаа, хамралт, үнэн зөв байдал ялгаатай тул нэгтгэх, харьцуулах боломжгүй, динамик хандлага харахад хэцүү;
- Мэдээллүүдийг хооронд нь уялдуулах, чанарын шалгалтууд хийж сайжруулах байдал хангалтгүй;
- Анхдагч эх үүсвэрээр цуглуулсан мэдээлэл нь дутуу, эсвэл хангалттай дэлгэрэнгүй биш байдаг зэрэг юм.

Улс орнууд гадаад шилжих хөдөлгөөний мэдээллээ чанартай бэлтгэхийн тулд анхдагч эх үүсвэрийн мэдээллүүдээ Бүдүүвч 1-д үзүүлсэн байдлаар ангилж, нэгтгэхийг НҮБ-аас зөвлөдөг.

Бүдүүвч 1. Анхдагч мэдээллийн эх үүсвэрүүдээрх гадаад шилжих хөдөлгөөний мэдээллийг ангилах, нэгтгэх НҮБ-ын зөвлөмж



Жич: Дээрх бүх шилжилтийн төрлүүдийг хугацааг нь нарийвчлан бүртгэхийн дээр, шилжигчдийн дагалдан яваа хамааралтай хүмүүсийг үндсэн шилжигчээс тусдаа бүртгэж мэдээлнэ.

Эх сурвалж: United Nations, Department of Economic and Social Affairs, Statistics Division (1998).

3. МОНГОЛ УЛСЫН ГАДААД ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨНИЙ МЭДЭЭЛЛИЙН ТУЛГАМДСАН АСУУДАЛ

Монгол Улсад гадаад шилжих хөдөлгөөний статистик үзүүлэлтүүдийг тооцож гаргахдаа ҮСХ-ны даргын 2013 оны 149-р тогтоолын хавсралтаар батлагдсан “Хүн амын статистикийн үндсэн үзүүлэлт тооцох аргачлал”-ыг баримталж байна. Уг аргачлалд зааснаар гадаад шилжих хөдөлгөөнд оролцогч гэдэг нь байнга оршин суудаг улс орноосоо 183 хоногоос дээш хугацаагаар өөр улсад шилжигч хүнийг хэлэх ба дараах хүмүүсийг хамруулна гэжээ. Үүнд:

Монгол Улсын иргэний хувьд:

- Гадаадад 183 хоногоос дээш хугацаагаар шилжин явж буй хүн (1)
- Гадаадад 183 хоногоос дээш хугацаагаар оршин сууж байгаад эх орондоо 183 хоногоос дээш хугацаагаар шилжин ирж буй хүн (2)

Гадаадын иргэн, харьяалалгүй хүний хувьд:

- Монгол Улсад 183 хоногоос дээш хугацаагаар оршин сууж байгаад

гадаадад 183 хоногоос дээш хугацаагаар шилжин явж буй хүн (3)

- Монгол Улсад 183 хоногоос дээш хугацаагаар шилжин ирж буй хүн (4)

(1)-(4) төрлийн шилжигчдийн мэдээллийг Монгол Улсад ямар мэдээллийн эх сурвалжууд гаргаж байгаа, тэдгээрийн онцлог, хязгаарлагдмал талуудын талаарх мэдээллийг нэгтгэн Хүснэгт 1а, Хүснэгт 1б-д харуулав.

Монгол Улс дахь гадаад шилжих хөдөлгөөний орох, гарах урсгал (*flow*)-ын анхдагч мэдээллийг одоогоор Хил хамгаалах ерөнхий газар (ХХЕГ) цуглуулдаг ба уг мэдээлэл 1990-ээд оны сүүлээс л албан ёсоор ҮСХ-ны мэдээллийн нэгдсэн сангаар дамжин олон нийтэд нээлттэй болсон. Харин *stock* мэдээллээс, Монгол Улсад оршин сууж буй гадаадын иргэдийн тооны анхдагч мэдээллийг Гадаадын иргэн, харьяатын газар (ГИХГ) хариуцан цуглуулдаг; гадаадад байнга оршин сууж буй монгол иргэдийн тооны мэдээллийг өнөөг хүртэл ҮСХ-оос 2010, 2020 онд явуулсан Хүн ам, орон сууцны тооллого (ХАОСТ)-оос өөр эх үүсвэр албан ёсоор зарлаагүй ба ийм тоог тогтмол бэлтгэдэг, олон нийтэд нээлттэй өөр эх үүсвэр байхгүй байна.⁶

⁶ Монгол Улсын ГХЯ гадаад улс орнууд дахь өөрийн элчин, консулын албадаараа дамжуулан гадаадад байнга оршин сууж буй монгол иргэдийн тоог гаргах ажлууд хийж байгаа ч үр дүнг дэлгэрэнгүйгээр албан ёсоор олон нийтэд мэдээлж байгаагүй, зөвхөн дотоод хэрэгцээнд ашиглаж ирсэн.

Хүснэгт 1а. Монгол Улсын харьяат иргэдийн гадаад шилжих хөдөлгөөний мэдээллийн гол анхдагч эх үүсвэрүүд

Шилжих хөдөлгөөн / шилжигчийн төрөл	Боломжит мэдээллийн эх үүсвэр	Монгол Улс дахь мэдээллийн эх үүсвэрийн байдал, анхаарах зүйлс
<p>(1)</p> <p>Гарах урсгал/ Шилжин явагч</p>	Захиргааны бүртгэл (Хилийн боомтын бүртгэл)	Хилээр гарсан монгол иргэдийн мэдээллээс 90 хоногоос дээш хугацаагаар, мөн байнга оршин суух, суралцах, ажиллах зорилгоор хил давсан иргэдээр жилийн турш дахь шилжин явагчдын тоог тооцон харах боломжтой. Иймд, энэ эх үүсвэрээр (1) төрлийн шилжигчдийн жил бүрийн flow тоо гарч байна. ⁷
	Захиргааны бүртгэл (Гадаад харилцаа, боловсрол, хөдөлмөр эрхлэлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагууд)	Монгол Улсын дипломат төлөөлөгчийн болон консулын газрууд гадаадад байгаа иргэдийн тоо, тэдний ердийн хөдөлгөөний бүртгэлийг хариуцдаг ч албан статистикуудаар мэдээлдэггүй, дотоод хэрэгцээнд л ашиглаж ирсэн. Уг мэдээлэл нь (1) төрлийн шилжигчдийн Stock мэдээлэл болно. БШУЯ-ны албан статистикаар Монгол Улсын засгийн газрын шугамаар гадаадад суралцагчдын тоог мэдээлдэг ба энэ нь (1) төрлийн шилжигчдийн жил бүрийн Stock мэдээлэл болно. Гэхдээ засгийн газрын биш шугамаар суралцагчдын тоо тодорхойгүй байна. Мөн ХНХЯ-ны ХХҮЕГ хөдөлмөрийн гэрээгээр гадаадад ажиллахаар явж буй иргэдийн бүртгэл (flow болон Stock тоо гарах боломжтой)-ийг хариуцдаг ч мэдээлэл нь статистикаар зарлагддаггүй, ажиллахаар явсан иргэдийн буцсан хөдөлгөөний мэдээлэл байхгүй байна.
	Хүн ам, орон сууцны тооллого (ҮСХ)	2010, 2015, 2020 оны тооллогуудаар гадаадад 6 сараас дээш хугацаагаар амьдарч байгаа Монгол Улсын харьяат иргэдийг тоолсон. Иймд (1) төрлийн шилжигчдийн Stock тоо, тэдний шинж байдал, явсан хугацаа, зорилго зэргийн талаарх мэдээлэл гарна.
	Хүн ам, өрхийн бүртгэл (ҮСХ)	ҮСХ санаачлан хороо/баг гэсэн захиргааны анхан шатны нэгжүүд Хүн ам, өрхийн мэдээллийн сангийн бүртгэлийн хүрээнд гадаадад шилжин явсан хүмүүсийн тоо, статусын талаарх мэдээллийг цуглуулдаг ч статистикаар зарладаггүй. ҮСХ-ны тайлбараар бусад эх үүсвэрийн мэдээлэлтэй тулгах, шалгах, чанарыг сайжруулах ажлууд хийгдэж байгаа. Иймд, энэ эх үүсвэрээр (1) төрлийн шилжигчдийн flow, stock тоо гарахгүй байна.
Түүвэр судалгаа	Үндэсний түүвэрлэлттэй судалгаа байхгүй, ихэвчлэн бага хэмжээний, магадлалт бус түүвэрлэлтээр хийгдсэн судалгаанууд ⁸ байна. Тэдгээрээс (1) төрлийн шилжигчдийн flow болон stock мэдээлэл гаргах нь зохисгүй ба түүврээс хамааран хэлбэлзэл ихтэй тооцоо гарна. Харин түүвэр судалгаанаас шилжин явагчдын шинж байдал, шилжилтийн зорилго, үр нөлөө, гадаад дахь нөхцөл байдал зэрэг нарийвчилсан сэдвүүдээр мэдээлэл гарна.	

⁷ Хилээр гарсан иргэдийн зорилгын мэдээллийг, тухайлбал “хувийн зорилгоор” гэсэн ангиллыг илүү нарийвчлан задлаж үзвэл шилжигчдийн тоо нэмэгдэх магадлалтай.

⁸ Тухайлбал, ХХССТ, ХНХЯ, НҮБХАС (2017); МХАХН, НХХЯ, НҮБХАС (2005); Солонго.А (2011); Монголбанк (2012); Монголбанк (2013); бусад хувь судлаачдын судалгаанууд

(2) Орох урсгал/ Шилжин ирэгч	Захиргааны бүртгэл (Хилийн боомтын бүртгэл)	Одоо мэдээлэгдэж буй хилээр орсон Монгол иргэдийн мэдээллээс шилжих хөдөлгөөнд оролцогч болон шилжих хөдөлгөөнд хамаарахгүй төрлийн хөдөлгөөнд оролцогчийг ялган харах боломжгүй байгаа. Өөрөөр хэлбэл, энэ эх үүсвэрээр (2) төрлийн шилжигчдийн flow тоо гарч чадахгүй байна.
	Хүн ам, орон сууцны тооллого (ҮСХ)	Төрснөөс хойших, тооллогоос өмнөх 5 жил, тооллогоос өмнөх 1 жилийн доторх шилжин ирэгчдийн тооцоонуудад гадаадаас ирэгчдийн тоо орсон. Шилжигч иргэн дээрх хугацаанд хэдэн удаа шилжсэнийг үл харгалзан хамгийн сүүлийн шилжих хөдөлгөөнийх нь хувьд аль улсаас Монголд ирсэн байршлыг тодорхойлсон. Иймд, (2) төрлийн шилжигчдийн тооллогоос өмнөх 1 жил, 5 жил, төрснөөс хойших хугацааны интервал доторх flow тоо, тооллогын оны stock тоо гарч байна.
	Хүн ам, өрхийн бүртгэл (ҮСХ)	Хороо/баг гэсэн захиргааны анхан шатны нэгжүүд Хүн ам, өрхийн мэдээллийн сангийн бүртгэлийн хүрээнд гадаадаас байнга оршин суухаар ирсэн хүмүүсийн тоо, статусын мэдээллийг өрхөөс цуглуулдаг ч статистикаар зарладаггүй. Иймд, энэ эх үүсвэрээр (2) төрлийн шилжигчдийн flow болон stock тоо гарахгүй байна.
	Түүвэр судалгаа (ҮСХ, бусад байгууллага, хувь судлаачид)	Гадаадад шилжин явагчдаас Монгол Улсдаа буцаж шилжин ирсэн иргэдийг хамруулсан судалгаанууд орно. Үндэсний хэмжээний түүвэрлэлттэй судалгаа байхгүй, ихэвчлэн бага хэмжээний, магадлалт бус түүвэрлэлтээр хийгдсэн судалгаанууд ⁹ байна. Шилжих хөдөлгөөнийг онилон судлаагүй ч ҮСХ-ны Ажиллах хүчний түүвэр судалгаа-аас (2) төрлийн шилжигчдийн судалгаанаас өмнөх 5 жил доторх flow тоо, судалгааны үеийн stock тоо гарна. Бусад судалгаанаас шилжин ирэгчдийн шинж байдал, нөхцөл байдлын мэдээлэл гарна.

Хүснэгт 16. Гадаадын иргэн, харьяалалгүй хүмүүсийн Монгол Улс дахь гадаад шилжих хөдөлгөөний мэдээллийн гол анхдагч эх үүсвэрүүд

Шилжих хөдөлгөөн/шилжигчийн төрөл	Боломжит мэдээллийн эх үүсвэр	Монгол Улс дахь мэдээллийн эх үүсвэрийн байдал, анхаарах зүйлс
(3) Гарах урсгал/ Шилжин явагч	Захиргааны бүртгэл (Хилийн боомтын бүртгэл)	Одоо мэдээлэгдэж буй Хилээр гарсан гадаадын иргэдийн мэдээллээс шилжих хөдөлгөөнд оролцогч болон шилжих хөдөлгөөнд хамаарахгүй төрлийн хөдөлгөөнд оролцогчийг ялган харах боломжгүй байна. Өөрөөр хэлбэл энэ эх үүсвэрээр (3) төрлийн шилжигчдийн flow тоо гарч чадахгүй байна
	Захиргааны бүртгэл (Гадаадын иргэн харьяатын газар буюу ГИХГ)	ГИХГ нь Монгол Улсад түр, урт, байнга хугацаагаар оршин суугаа гадаад, цагаач, харьяалалгүй иргэд, мөн Монгол Улсын харьяат болсон иргэд, харьяатаас гарсан иргэдийн асуудлыг хариуцдаг ба оршин суух зөвшөөрлийн хасалт хийдэг ч тэдний гарах хөдөлгөөнийг бүртгэдэггүй тул (3) төрлийн шилжигчдийн flow мэдээлэл гарахгүй, stock тоо гарч байна.
	Хүн ам, орон сууцны тооллого (ҮСХ)	ХАОСТ-оор (3) төрлийн шилжигчдийн flow, stock аль ч мэдээлэл гардаггүй.

⁹ Тухайлбал, МХАХН, НҮБХАС (2005); ХХССТ, ХНХЯ, НҮБХАС (2017); “Хэвлэлийн хүрээлэн” ТББ, НЗХГ (2018)

	Хүн ам, өрхийн бүртгэл (ҮСХ)	ҮСХ санаачлан хороо/баг гэсэн захиргааны анхан шатны нэгжүүд Хүн ам, өрхийн мэдээллийн сангийн бүртгэлийн хүрээнд гадаадад шилжин явагчдын тоо, статусын талаарх мэдээллийг цуглуулдаг ч статистикаар зарладаггүй. ҮСХ-ны тайлбараар бусад эх үүсвэрийн мэдээлэлтэй тулгах, шалгах, чанарыг сайжруулах ажлууд хийгдэж байгаа. Иймд, энэ эх үүсвэрээр (3) төрлийн шилжигчдийн flow болон stock тоо гарахгүй байна.
	Түүвэр судалгаа	(3) төрлийн шилжигчидтэй холбоотой түүвэр судалгаа Монгол Улсад хийгдээгүй байна.
(4) Орох урсгал/ Шилжин ирэгч	Захиргааны бүртгэл (Хилийн боомтын бүртгэл)	Хилээр орсон гадаадын иргэдийн мэдээллээс байнга оршин суух, суралцах, ажиллах зорилгоор орж ирсэн иргэдээр жилийн турш дахь шилжин ирэгчдийн тоог тооцон харах боломжтой. ¹⁰ Иймд, энэ эх үүсвэрээр (4) төрлийн шилжигчдийн жил бүрийн flow тоо гарна.
	Захиргааны бүртгэл (Гадаадын иргэн харьяат, хөдөлмөр эрхлэлт, боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагууд)	ГИХГ нь Монгол Улсад түр, байнга хугацаагаар оршин суугаа гадаад, цагаач, харьяалалгүй иргэд, мөн Монгол Улсын харьяат болсон иргэд, харьяатаас гарсан иргэдийн асуудлыг хариуцдаг ба (4) төрлийн шилжигчдийн flow болон stock тоо мэдээлэл жил бүрээр гарна. БШУЯ-аас Монгол Улсын нутагт үйл ажиллагаа явуулж буй боловсролын байгууллагад суралцагч гадаадын иргэдийн тоог жил бүр гаргаж байгаа нь (4) төрлийн шилжигчдийн Stock тоо болно. Мөн ХНХЯ-ны ХХҮЕГ-аас хөдөлмөр эрхлэх зорилгоор Монгол Улсад оршин суугаа гадаад иргэдийн тоо, хөдөлмөр эрхлэлттэй холбоотой мэдээллийг жил бүр гаргадаг нь (4) төрлийн шилжигчдийн stock тоо болно.
	Хүн ам, орон сууцны тооллого (ҮСХ)	Төрснөөс хойших, тооллогоос өмнөх 5 жил, тооллогоос өмнөх 1 жилийн доторх шилжин ирэгчдийн тоонуудад гадаадаас ирэгчдийн тоо орсон. Шилжигч иргэн дээрх хугацаанд хэдэн удаа шилжсэнийг үл харгалзан хамгийн сүүлийн шилжих хөдөлгөөнийх нь хувьд аль улсаас Монголд ирсэн байршлыг тодорхойлсон. Иймд, (4) төрлийн шилжигчдийн тооллогоос өмнөх 1 жил, 5 жил, төрснөөс хойших хугацааны интервал доторх flow тоо, тооллогын оны stock тоо гарна.
	Хүн ам, өрхийн бүртгэл	Хороо/баг гэсэн захиргааны анхан шатны нэгжүүд Хүн ам, өрхийн мэдээллийн сангийн бүртгэлийн хүрээнд гадаадаас шилжин ирэгчдийн тоо, статусын мэдээллийг цуглуулдаг ч статистикаар зарладаггүй. Иймд, энэ эх үүсвэрээр (4) төрлийн шилжигчдийн flow болон stock тоо гарахгүй байна.
	Түүвэр судалгаа	Монгол Улсад оршин сууж буй гадаад иргэдийг хамруулсан сэдэвчилсэн судалгаа маш цөөн, хөдөлмөр эрхлэлт, гадаад оюутнуудын чиглэлээр зарим судалгаа ¹¹ байгаа ч түүвэр, хамарсан асуудлын хувьд нэлээд хязгаарлагдмал байна. Иймд, энэ эх үүсвэрээр (4) төрлийн шилжигчдийн flow болон stock тоо гарахгүй байна.

¹⁰ Хилээр орсон иргэдийн зорилгын мэдээллийг, тухайлбал “хувийн зорилгоор” гэсэн ангиллыг илүү нарийвчлан задлаж шинжилбэл, шилжигчдийн тоо өөрчлөгдөх боломжтой.

¹¹ Тухайлбал, Монголбанк (2014).

Дээрх хүснэгтүүдээс харахад, Монгол Улсад 1990-ээд оноос идэвхжсэн гадаад шилжих хөдөлгөөний талаарх мэдээллийн эх үүсвэрүүд нэлээд олон төрөлтэй байгаа ч тус бүрийнх нь чанар, хүртээмжид анхаарах зүйл багагүй байна. Тухайлбал:

1. Гадаадаас буцан ирж буй дотоодын шилжигчид, гадаад руу буцаж буй гадаадын шилжигчдийн микро, макро түвшний албан ёсны тоо мэдээлэл flow болон stock хэлбэрээр маш хязгаарлагдмал, бараг байхгүйтэй адил байна.¹² Зөвхөн 2010 оны ХАОСТ-ын “Шилжих хөдөлгөөн, суурьшил” сэдэвчилсэн судалгаагаар гадаадад байнга оршин сууж байгаад Монгол Улсад буцаж ирсэн Монгол Улсын харьяат иргэдийн шилжих хөдөлгөөнийг төрснөөс хойш, тооллогоос өмнөх 5 жилд, тооллогоос өмнөх 1 жилд гэсэн байдлаар хамгийн сүүлчийн шилжих хөдөлгөөний байршлаар нь гадаадын шилжигчдийн тоотой хамтатган тооцон гаргасан байна.
2. Монгол Улсын гадаад шилжих хөдөлгөөний агрегат тоо мэдээллийг динамик хандлагаар буюу цаг хугацаагаар харьцуулан судлах боломж зөвхөн flow төрлийн мэдээлэлд л байгаа ба stock төрлийн мэдээлэлд хязгаарлагдмал байна.
3. Хилийн боомтуудын улсын хилээр орсон, гарсан иргэдийн тоо нь гадаад шилжих хөдөлгөөний flow мэдээллийн чухал эх үүсвэр болж байгаа ч шилжих хөдөлгөөний үзүүлэлтүүдийг олон улсад харьцуулагдахуйцаар тооцох боломж олгож чадахгүй, хамралт дутуу байна. Тухайлбал:
 - Гадаадад шилжээд буцах шилжих хөдөлгөөнөөр ирж буй дотоодын шилжигчид, гадаад руу буцаж буй гадаадын шилжигчдийн тоо мэдээлэл гарах боломжгүй.
 - Хилээр орсон, гарсан иргэдийн зорилгын талаарх ангилал “хувийн зорилгоор” гэх мэт хэт ерөнхий байгаагаас ямар төрлийн шилжих хөдөлгөөн явагдаж буйг ялгаж тодорхойлоход дутагдалтай байна.

- Монгол Улсын иргэдийн гадаад руу явж байгаа хугацааны ангиллыг хэт ерөнхий (30 хүртэл хоног, 30-90, 90-ээс дээш хоног гэж) бүртгэж байгаагаас уг хөдөлгөөн нь шилжих хөдөлгөөнд тооцогдохгүй хөдөлгөөн, аялал жуулчлалд тооцогдох хөдөлгөөн, эсхүл түр, байнгын шилжих хөдөлгөөн эсэхийг нарийн ялгах боломжгүй байна.
 - Мэдээллүүд нь НҮБ-ын зөвлөмжийн дагуу иргэдийн нас, хүйс гэх мэтээр задраагүй, хэт ерөнхий бүтэцтэй байна.
4. Мэдээллийг тогтмол цуглуулж судлаачид, олон нийтэд тархах байдал хилийн бүртгэл, 10 жилд нэг удаа явагддаг ХАОСТ-оос бусад эх үүсвэрт хязгаарлагдмал байна. Бодлогын баримт бичгүүддээ¹³ ҮСХ-оос гадна төрөлжсөн захиргааны байгууллагуудын статистикаар гадаад шилжих хөдөлгөөний мэдээллийг гаргахаар заасан байдаг ч тэдгээр эх үүсвэрийн мэдээлэл хөтлөлт дутуу, тархаалт хүртээмж муутай байна. Тухайлбал:
 - ГХЯ гадаад орнууд дахь өөрийн элчин, консулын албадаараа дамжуулан гадаадад байнга оршин сууж буй монгол иргэдийн тоог гаргах үүргийг хариуцдаг ч мэдээллийг албан ёсоор олон нийтэд мэдээлдэггүй, зөвхөн дотоод хэрэгцээнд ашиглаж ирсэн.
 - ХНХЯ, түүний харьяа судалгааны институт (ХНХСИ) ажиллах хүчний шилжих хөдөлгөөнтэй холбоотой зарим тоо мэдээлэл бүрдүүлдэг ч дотоод хэрэгцээнд л ашигладаг.
 - БШУЯ-аас Монгол Улсад суралцаж буй гадаадын иргэдийн мэдээллийг албан ёсоор зарладаг ч, Монгол Улсаас гадаадад суралцаж буй суралцагчдын тоог бүрэн бүртгэж, мэдээлж чадахгүй байна. Тодруулбал, зөвхөн Засгийн газрын тэтгэлэг, дээд боловсролын зээлийн сангийн зээл зэргээр гадаадад суралцагчдыг бүртгэдэг ч, бусад шугамаар суралцагчдын тоог бүртгэх систем бүрдээгүй, тоо мэдээлэл нь тодорхойгүй байна.

¹² Шилжих хөдөлгөөний үр нөлөөг хэмжих, бодлого, хөтөлбөрүүдийн төлөвлөлт, хэрэгжилтийн үнэлгээнд буцах шилжих хөдөлгөөний flow болон stock мэдээллүүд чухал байдаг.

¹³ УИХ-аар 2011 онд батлагдсан Монгол улсын гадаад бодлогын үзэл баримтлал-ын 27.2-р зүйл, 2010 онд баталсан Монгол улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал-ын 3.1.3.5-р зүйл

- ГИХГ-ын Монгол Улс дахь гадаадын шилжигчид, иргэдийн талаар бүртгэдэг мэдээлэл нь чанар, стандартын хувьд статистикийн байгууллагын бэлтгэдэг мэдээллийн түвшинд хүрэхгүй байна.
- 5. Монгол Улсын хувьд урт хугацааны гадаад шилжих хөдөлгөөнийг тодорхойлоход ашиглаж буй босго хугацаа 6 сар байгаа нь НҮБ-ын зөвлөмж (1 жил)-өөс өөр байгаа тул олон улсын судалгаануудтай харьцуулан судлахад хүндрэлтэй байна.
- 6. Дотоодын эх үүсвэрүүдээр Монгол Улс дахь гадаадын иргэдийн тоо мэдээлэл зөрүүтэй байна.
- 7. Байгаа мэдээллүүдэд нарийвчилсан судалгаа шинжилгээ хийгдсэн байдал бага байна.

Түүнчлэн Монгол Улс хөгжлийн бодлогын хэрэгжилтийн үнэлгээнд шаардлагатай шилжих хөдөлгөөний бусад тоо мэдээллийг бэлэн байлгах чиглэлээр олон улсад хүлээсэн үүргээ биелүүлэхэд хүндрэл байсаар байна. **Тухайлбал**, 2018 оны эцсийн байдлаар Монгол Улс **Үндэсний** тогтвортой хөгжлийн зорилгууд дахь шилжих хөдөлгөөнтэй шууд болон шууд бусаар холбоотой 10 зорилтыг үнэлэх 12 шалгуур үзүүлэлтүүдийн дөнгөж 5 үзүүлэлтийн талаарх мэдээллийг албан ёсны статистикаар гаргаж байна.¹⁴

Олон улсын ба дотоодын мэдээлийн эх үүсвэрүүдээрх Монгол Улсын гадаад шилжих хөдөлгөөний бүртгэгдсэн анхдагч тоог харьцуулж үзвэл, дотоодын эх сурвалжийн тоо НҮБ-ын эх сурвалжинхаас *flow* мэдээлэл нь 16-30 гаруй дахин өндөр, *stock* мэдээлэл нь ойролцоогоор 2 дахин өндөр дүнтэй байна. Тухайлбал, 2010 оны ХАОСТ-оор Монгол Улсын харьяат 107,140 хүн гадаадад байнга оршин сууж байгаа¹⁵ гэж тоологдсон нь НҮБ-ын ижил мэдээллээс 1.9 дахин илүү, 2020 оны үндэсний тооллогоор тоологдсон гадаадад оршин сууж буй хүний дүн (122,301) НҮБ-ын

мэдээллээс 1.7 дахин өндөр дүнтэй байна. Мөн ГХЯ-ны мэдээллээр¹⁶ 2016 оны эцэст Монгол Улсын харьяат 144,566 иргэн хилийн чанадад оршин сууж байгаа гэсэн нь НҮБ-ын тооцооллоос ойролцоогоор 2.5 дахин илүү байна. Харин Монгол Улсад оршин суугаа гадаадын иргэдийн тоо НҮБ-ын ба үндэсний тооллогын эх сурвалжуудаар зөрүү багатай байна. Дээрх мэдээллийн зөрүүтэй буюу нийцгүй байдал нь судлаачид, шийдвэр гаргагчид Монгол Улсын гадаад шилжих хөдөлгөөний талаар бодит бус дүгнэлт хийхэд хүргэж болзошгүйг анхааруулж байгаа тул хариу арга хэмжээ авах нь зүйтэй юм.

4. ДҮГНЭЛТ, САНАЛ

Монгол Улс хүн амаа өсгөх бодлоготой бөгөөд гадаад шилжих хөдөлгөөний бодлогын хувьд гадаадын иргэдийн шилжин ирэх хөдөлгөөнд тийм ч нээлттэй биш, харин гадаадад байгаа иргэдээ эргүүлэн татах сонирхолтой оронд тооцогддог.¹⁷ Тэрхүү бодлогын зорилтдоо хүрэх, улмаар гадаад шилжих хөдөлгөөний хөгжилд оруулах хувь нэмрийг нэмэгдүүлэх, шилжих хөдөлгөөний бодлого, зохицуулалтаа боловсронгуй болгох, мөн шилжих хөдөлгөөний түвшин, цаашдын хандлагыг зөв үнэлэхэд хүртээмжтэй, чанартай тоо мэдээлэл Монгол Улсад хэрэгцээтэй хэвээр байна. Тухайлбал, Монгол Улсын харьяат ба харьяат бус иргэдийн буцах шилжих хөдөлгөөний албан ёсны тоо мэдээлэл микро, макро түвшинд бараг байхгүйтэй адил; гадаад шилжих хөдөлгөөний хандлагыг цаг хугацаагаар харьцуулан судлах боломж зөвхөн “шилжих хөдөлгөөний урсгал” мэдээллээс боломжтой ч тэр нь шилжих хөдөлгөөний үзүүлэлтүүдийг олон улсад харьцуулагдахуйцаар тооцох боломж олгож чадахгүй, хамралт дутуу; ойлголт, тодорхойлолтын зөрүүтэй байдлаас шалтгаалан Монгол Улсын гадаад шилжих

¹⁴ ҮСХ-ны мэдээллийн нэгдсэн сан (<http://sdg.gov.mn/Home/Availability>)

¹⁵ Монгол Улсад мөрдөгдөж буй хууль, тогтоомжийн дагуу гадаадад 183, түүнээс дээш хоногоор оршин сууж байгаа хүмүүсийг оруулсан.

¹⁶ Монгол Улсаас хилийн чанадад суугаа Дипломат төлөөлөгчийн газруудаас ГХЯ-нд ирүүлсэн бүртгэлийн мэдээлэл (хэвлэгдээгүй, албан хэрэгцээнд байгаа тоо).

¹⁷ Монгол Улс гадаад шилжих хөдөлгөөнтэй холбоотой олон улсын гол гэрээ конвенцуудаас дүрвэгчид, шилжигч ажилчидтай холбоотой конвенцид нэгдэн ороогүй; Шилжигчид хүлээн авахдаа өндөр ур чадвартай ажилчид болон тодорхой салбар дахь хөдөлмөрийн хангагдаагүй эрэлтийг нөхөх чиглэлээр л гадаадаас ажилчин авдаг; гадаадын иргэнд хувийн хэргээр оршин суух, цагаачлах эрх олгохыг хатуу шалгуур, квоттойгоор зөвшөөрдөг. Мөн гадаадад сурч, хөдөлмөрлөж байгаа иргэддээ эх орондоо эргэн ирж ажиллаж, амьдрах таатай нөхцөл, боломжийг бүрдүүлэх; улсынхаа хөгжилд хувь нэмрээ оруулахыг нь дэмжих; гадаадад төрж тухайн улсын иргэний харьяалалтай болсон иргэд, тэдний үр хүүхдэд Монгол Улсад зорчих, оршин суух, суралцах, ажиллаж амьдрах, даатгалд хамрагдах таатай нөхцлийг бүрдүүлэх зэрэг агуулгатай заалтуудыг төрийн бодлогын хэд хэдэн баримт бичгүүддээ зааж, тодорхой хөтөлбөрүүд ч гаргасан байдаг.

хөдөлгөөнийг олон улсын судалгаануудтай харьцуулан судлахад хүндрэлтэй; бодлогын баримт бичгүүдэд мэдээлэл цуглуулах, хөтлөхтэй холбоотой үүрэг хүлээсэн захиргааны байгууллагуудын мэдээлэл хөтлөлт, тархаалт хангалтгүй зэргийг онцолж болохоор байна. Түүнчлэн дотоодын эх үүсвэрүүдийн *flow, stock* мэдээллүүдээр бүртгэсэн гадаад шилжих хөдөлгөөний цэвэр тоо олон улсын эх сурвалжийн мэдээнээс дор хаяж 2 дахин зөрүүтэй байгаа нь олон улсад Монгол Улсын шилжих хөдөлгөөний талаарх нөхцөл байдлыг алдаатай үнэлж, ойлгож болохуйц нөхцлийг үүсгэж байна. Иймд, Монгол Улсын гадаад шилжих хөдөлгөөний одоогийн тоо мэдээллийн чанар, хүртээмжийг сайжруулах чиглэлээр дараах ажлуудыг хийх нь зүйтэй гэсэн саналыг дэвшүүлж байна. Үүнд:

1. Тооллого болон захиргааны бүртгэлүүд Монгол Улсын харьяат болон гадаадын харьяат иргэдийн хөдөлгөөний мэдээллийг ялгаж, Бүдүүвч 1 дэх НҮБ-ын зөвлөмж ангиллын дагуу бүртгэж, мэдээлдэг болох. Ялангуяа буцах шилжих хөдөлгөөний талаарх бүртгэл, мэдээлэл байхгүй байгааг анхаарч, мэдээлэл бүрдүүлэхэд анхаарах.
2. Гадаад шилжих хөдөлгөөний *flow* тоо мэдээллийн гол эх сурвалж болох хилийн боомтын бүртгэлийн мэдээлэл бүрдүүлэлт, боловсруулалт, тархаалтыг НҮБ-ын зөвлөмж, дотоодын статистикийн байгууллагын журам, аргачлалд заасантай нийцүүлэн илүү боловсронгуй болгох. Тухайлбал, гадаад руу явж байгаа хугацааны ангиллыг мэдээлэхдээ 30 хүртэл хоног, 30-90 хоног, 90-ээс дээш хоног гэснийг 30 хүртэл, 31-90, 91-182, 183-365, 365-аас дээш хоног гэх зэргээр нарийвчлан гаргадаг болсноор гадаад шилжих хөдөлгөөн түр, эсхүл байнгын эсэхийг ялгах, олон улстай харьцуулсан судалгаа хийх боломжтой болно. Мөн хөдөлгөөний зорилгыг бүртгэхдээ “хувийн журмаар, бусад” зэрэг хэт ерөнхий ангилсан зорилгын ангиллыг задалж, илүү тодорхой болгох.
3. Дотоодын захиргааны гаралтай мэдээллүүдийг “статистик мэдээлэл болгох” талаас анхаарах. Тодруулбал, мэдээлэл бүртгэх, боловсруулахдаа олон улсын болон дотоодын статистикийн байгууллагын зөвлөмж, стандартыг

баримтлах, мэдээллээ олон нийтэд түгээдэг болох.

4. Тооллого болон томоохон түүвэрлэлттэй судалгаануудын хүрээнд асуудаг гадаад шилжих хөдөлгөөний холбогдолтой асуулт, мэдээллийг арай дэлгэрэнгүй цуглуулж, мэдээлдэг болох.
5. Цаашид гадаад шилжих хөдөлгөөний мэдээллийг Хүн ам, өрхийн мэдээллийн сан гэх мэт өрхөд суурилсан албан бүртгэл, мэдээллийн системээр цуглуулж, албан статистиктай холбон, тогтмол мэдээлдэг болох.
6. Гадаад шилжих хөдөлгөөний боломжит мэдээллийн эх үүсвэрүүдийн мэдээллийг хооронд нь тулган, хамралт, агуулга, чанарын шалгалтууд хийж сайжруулж байх, хооронд нь уялдуулах.
7. Гадаад шилжих хөдөлгөөний талаарх нэгдсэн мэдээллийн системтэй болох.
8. Дотоодын болон олон улсын мэдээллийн эх үүсвэрүүдийн зөрүүтэй мэдээллийн учир шалтгааныг тогтоож, мэдээллийн чанарыг сайжруулах тал дээр анхаарах.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

Монгол хэлээр:

Монгол Улсын Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай хууль

Монгол Улсын Гадаадын иргэний эрх зүй байдлын тухай хууль

Монгол Улсын иргэн гадаадад хувийн хэргээр зорчих, цагаачлах тухай хууль

Монгол Улсын Хүн ам, орон сууцны улсын тооллогын тухай хууль

Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал (2010)

Монгол Улсын Гадаад бодлогын үзэл баримтлал (2011)

Монгол Улсын төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлого (2016-2025)

Монгол Улсад бүртгэлийн нэгдсэн тогтолцоог бий болгох үндэсний хөтөлбөр (2008-2012)

Монгол Улсын Засгийн Газар, “Зөгийн үүр” хөтөлбөр (2012-2016)

- Монгол Улсын Засгийн Газар, “Дэлхийн монголчууд” хөтөлбөр (2016-2020) судалгаа №13), Улаанбаатар (http://web.nso.mn/nadamn/index.php/catalog/126/related_materials)
- Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны 2012-2016, 2016-2020 оны хөтөлбөрүүд ҮСХ (2011в). Хүн ам, орон сууцны 2010 оны улсын тооллого: Шилжих хөдөлгөөн, суурьшил (сэдэвчилсэн судалгаа №2), Улаанбаатар (http://web.nso.mn/nadamn/index.php/catalog/126/related_materials)
- Монгол Улсад хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөр ҮСХ (2013а). Хүн амын статистикийн үндсэн үзүүлэлт тооцох аргачлал (ҮСХ-ны даргын 2013 оны 12-р сарын 25-ны өдрийн 1/149 тоот тушаалын хавсралт)
- Болормаа.Ц (2019). “Монгол Улс: Ажиллах хүчний гадаад шилжилт хөдөлгөөн”, Монголын хүн амын сэтгүүл, дугаар (499), 29, 2019, 9-18-р тал ҮСХ (2020). Хүн ам, орон сууцны 2020 оны улсын ээлжит тооллогын нэгдсэн дүн, Улаанбаатар: Би Си Ай
- Монголбанк (2012). Гадаадад суралцаж буй монгол иргэдийн зардлын түүвэр судалгааны хураангуй тайлан (<https://www.mongolbank.mn/documents/tovhimol/group8/8-10.pdf>) ҮСХ (2019). Ажиллах хүчний судалгааны үндсэн тайлан 2018, Улаанбаатар
- Монголбанк (2013). БНЧУ-д ажиллаж, амьдарч буй монгол иргэдийн мөнгөн гуйвуулгын хэмжээг тооцоолох түүвэр судалгаа (<https://www.mongolbank.mn/documents/statistic/externalsector/samplesurvey/BOPczech.pdf>) ХНХСИ (2016а). БНСУ, Япон улсад хөдөлмөр эрхэлж буй болон эх орондоо эргэн ирсэн иргэдийн нөхцөл байдлын судалгаа (дотоод хэрэгцээнд зориулан бэлтгэсэн тайлан)
- Монголбанк (2014). Монгол Улсад ажиллаж буй гадаад ажилтнуудын цалингийн судалгаа (https://www.mongolbank.mn/documents/statistic/externalsector/samplesurvey/salary_foreign.pdf) ХНХСИ (2016б). Ажиллах хүчний гадаад шилжих хөдөлгөөний өнөөгийн нөхцөл байдалд хийсэн баримт бичгийн шинжилгээ (дотоод хэрэгцээнд зориулан бэлтгэсэн тайлан)
- МХАХН, НХХЯ, НҮБХАС (2005). Монгол иргэдийн гадаадад хөдөлмөр эрхлэлтийн байдал, үр дагавар судалгааны тайлан, Улаанбаатар ХНХЯ, ХНХСИ (2016). Ажиллах хүчний гадаад шилжих хөдөлгөөний нөхцөл байдлын судалгаа (дотоод хэрэгцээнд зориулан бэлтгэсэн тайлан)
- Солонго.А (2011). “Гадаадад ажил эрхлэхийн төлөөх шилжих хөдөлгөөн: Хүн ам зүйн тулгамдсан асуудлууд”, *Монголын хүн амын сэтгүүл*, дугаар (367) 20, 2011, 48-52-р тал ХХССТ, ХНХЯ, НҮБХАС (2017). Гадаад шилжих хөдөлгөөний тоон ба чанарын судалгаа (ХНХЯ-ны дотоод хэрэгцээнд байгаа хэвлэгдээгүй тайлан)
- Солонго.А (2012). “Шилжигч ажилчид: Хууль эрх зүйн орчин ба нийгэм эдийн засгийн үр нөлөө”, *Монголын хүн амын сэтгүүл*, дугаар (379) 21, 2012, 9-24-р тал “Хэвлэлийн хүрээлэн” ТББ, НЗХГ (2018). Гадаадад сурч, боловсрол эзэмшсэн залуучуудын судалгаа (http://youth.ub.gov.mn/wp-content/uploads/2019/01/Tailan-НХЗГ_Гадаадад-төгсөгчдийн-судалгаа.pdf)
- ҮСХ (2011а). Хүн ам, орон сууцны 2010 оны улсын тооллого: Нэгдсэн дүн, Улаанбаатар (http://web.nso.mn/nadamn/index.php/catalog/126/related_materials) ХЭҮК (2007). “БНСУ-д ажиллаж буй монгол иргэдийн зарим эрхийн хэрэгжилт” судалгааны тайлан (<http://upr-mongolia.mn/images/xupld/Migrantsfinal.pdf>)
- ҮСХ (2011б). Хүн ам, орон сууцны 2010 оны улсын тооллого: Гадаадад оршин суугаа Монгол Улсын иргэд (сэдэвчилсэн

Англи хэлээр:

Abel & Sander (2014). "Quantifying global international migration flows". *Science*, 343 (6178).

Edmonston.B & M.Michalowski (2004). "International migration", *The methods and materials of demography* (ed. Siegal.J.S & Swanson.D.A) (Second edition), ELSEVIER Academic Press

IMF (2009). *Balance of Payments and International Investment Position Manual*, sixth edition (BPM6), IMF Multimedia Services Division (www.imfbookstore.org)

IOM (2019b). *Glossary on migration*, IML Series No. 34, 2019.

IOM GMDAC (2018). *Global migration indicators 2018*. Germany

UN DESA, Population Division (2012). *Toolkit on International Migration*. (www.unmigration.org)

UN DESA, PD (2017a). *International migration report 2017: Highlights* (ST/ESA/SER.A/404).

UN DESA, PD (2017b). *International Migration Policies: Data Booklet*. (ST/ESA/SER.A/395).

UN DESA, Statistics Division (1998). *Recommendations on Statistics of International Migration, Revision 1. Statistical papers, Series M. No.58, Rev.1*, USA: New-York

United Nations, *Treaty Series*, vol.189, No.2545